



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 03 сарын 10 өдөр

Дугаар А/48

Арвайхээр

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжих Сургуулийн хичээлийн байрны засвар /Өвөрхангай, Богд сум/ ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Н.Ганболд -аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газрын дарга

Нарийн бичгийн дарга: Т.Гантулга -аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газрын ажил худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн

Гишүүд: Н.Дулам - аймагийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

Б.Одсүрэн – Мерси кор ОУБ-ын Өвөрхангай аймаг дахь салбарын зохицуулагч (зөвшилцсөнөөр)

Г.Гантөмөр -Оновчтой хөгжил ТББ-ын тэргүүн (зөвшилцсөнөөр)

2. Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, мэдэгдэл, гэрээний төслийг өргөн мэдүүлэхийг Үнэлгээний хороо (Н.Ганболд)-д даалгасугай.

3. Тендер шалгаруулалттай холбоотой баримт бичгээр хууль тогтоомжийн дагуу архивын нэгж бүрдүүлж, Архив, бичиг хэргийн ажилтанд хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Т.Гантулга)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ГАНБОЛД

012100193

D; My Doc. Tushaal. ZDTG